

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 429.3 сая төгрөг орж төлөвлөгөө 73.2 хувиар биелж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 317.8 саяар дээгүүр гүйцэтгэлтэй байна. Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 35.6 хувиар тасарч, Наран, Түмэнцогт, Уулбаян сумдын төлөвлөгөө давж биелэсэн байна.

Орон нутгийн зарлага санхүүжилт 224.2 сая төгрөг болж төлөвлөгдсөн хэмжээнээс 23.7 сая төгрөгөөр доогуур байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр** ХААН, Монгол шуудан, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 13.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 0.2 тэрбумаар өсчээ.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 7.0 тэрбум болж, 2009 оны жилийн эцсийн үлдэгдлээс 0.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. Аймгийн хэмжээгээр нийт 27 тооцооны төв ажиллаж байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй:** Оны эхний малын 0.16 хувь болох 2.5 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.7 дахин буюу 1.9 мянган малаар дээгүүр байна.

Түмэнцогт, Мөннххаан, Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан сумдад оны эхний малын 0.95 - 0.16 хувь нь зүй бусаар хорогдсон нь хамгийн их нь бөгөөд Дарьганга, Наран сумд хорогдолгүй байна.

**IV. БИЗНЕС РЕГИСТР:** 2009 оны жилийн эцсийн байдлаар Аж ахуйн нэгж, байгууллагын бизнес регистрийн санд 452 ААНБ бүртгэгдсэний 424 буюу 93.8 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуйн нэгж байгууллагын тоог 2008 оны жилийн эцэстэй харьцуулахад бүртгэлтэй аж ахуйн, нэгж байгууллага 43-аар буюу 10.5 хувь, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 39-өөр буюу 10.1 хувиар нэмэгдсэн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл: ХХК 40.1 хувийг, төрийн байгууллага 28.3 хувийг, ЗБН 8.7 хувийг, ТББ 7.5 хувийг, ББН 7.3 хувийг, Хоршоо 5.9 хувийг эзэлж байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3.0 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Оны үнээр 12.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 10.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 28.7-200 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифийн ерөнхий индекс 2009 оны жилийн

эцсийнхээс 3.6 хувиар өсөхөд хүнсний барааны үнэ 8.1 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисны үнэ 1.1 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.2 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэ тарифын ерөнхий индекс 8.6 хувиар өсөхөд амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний үнэ тариф 4.6 хувиар буурч, бусад бүлгийн барааны үнэ тариф 2.7-19.8 хувиар өссөн нь тус тус өссөн нь нөлөөлжээ.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** Эхний 1 сард 112 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үеэс 11 эхээр олон байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 байгаа нь урьд оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 50 болж урьд оны мөн үеэс Сүрьеэ өвчнөөр өвчлөгчдийн тоо өсч, бусад халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо буурсан байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1118 болж, урьд оны мөн үеийнхээс 51.7 хувиар өссөн байна. Ажилгүйчүүдийн 65.8 хувь нь 16-34 насны залуучууд, 19.2 хувь нь дээд, 5.6 хувь нь тусгай дунд, 37 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. 14 хүн шинээр бүртгүүлж, 91 хүн ажилд орсон байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** Эхний 1-р сард 14 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1-ээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 5 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2.5 сая төгрөгийн хохирол учирсны 0.8 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 11 хүн холбогдон сэжиглэгдсэний 27.3 хувь нь согтуугаар, 18.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 143 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 20-н хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 15 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 3 хүнээр дээгүүр байна.

Хэрэг илрүүлэлт 100 хувьтай байна.